

**ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ҮР
НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ**

**Улаанбаатар хот
2024 он**

АГУУЛГА

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

- 2.1. Зорилгод хүрэх байдал
- 2.2. Практикт хэрэгжих боломж
- 2.3. Ойлгомжтой байдал
- 2.4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал
- 2.5. Зардал
- 2.6. Харилцан уялдаа

ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

- 3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ
- 3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ
- 3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ
- 3.4. “Зардал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ
- 3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

- 4.1. Дүгнэлт
- 4.2. Зөвлөмж

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 2.6.16-т “Хүн амын бүлгүүд, тухайлбал ...ахмад настан хагас цагаар, гэртээ, зайнаас ажиллах уян хатан зохицуулалт бий болгоно.”, 3.1.13-т “Ахмад настанд урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэх хөгжлийн төвүүдийг байгуулна.”, 3.1.18-т “Ахмад настанд ... үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлнэ.” гэж тусгасан.

Энэ хүрээнд 2017 оны 1 дүгээр сарын 26-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн “Ахмад настны тухай” хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд холбогдох судалгааг хийсэн.

Уг судалгаагаар Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, ахмад настны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлэх зорилтыг эрчимжүүлэх, насжилтын үеийн өвчний эрсдэлийг нэмэгдүүлдэг хүчин зүйлүүдийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, ахмад настныг ажлын байраар хангаж байгаа ажил олгогч, аж ахуйн нэгжүүдийг татварын болон бусад бодлогоор дэмжих, ахмадын асрамж, хамгаалал, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин нөхцөлийг бий болгох асуудлаар цогц бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд хууль санаачлагчид дэмжлэг үзүүлэх, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхийг зорьсон болно.

**АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ
ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Энэхүү үнэлгээг “Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

“Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал” - /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийсэн.

1. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх;
4. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх.

**ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН
БАЙДАЛ**

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих байдал
3. Ойлгомжтой байдал
4. Зардал
5. Харилцан уялдаа зэрэг болно.

2.1. Зорилгод хүрэх байдал

Шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх /бүрэн илэрхийлж чадсан эсэх/, хуулийн төслийн үндсэн зорилго нь Ахмад настны хууль хэрэгжиж эхэлснээс хойш уг хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэхэд зарим саад бэрхшээл тулгарч байгаа тул уг шалтгааныг эрт илрүүлэх, цаашид хуулийг боловсронгуй болгоход чиглэгдэж байгааг анхаарч, хуулийн төслийн зохицуулалт, арга хэмжээ нь хуулийн төслийн зорилгод хүрэх боломжтой байна уу гэдгийг үнэллээ. Энэхүү үнэлгээг хийхийн тулд хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төслийн зорилго болон

зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авав.

2.2. Практикт хэрэгжих боломж

Шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг, мөн хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх вэ гэдгийг тогтоох, тэдгээр байгууллагад тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг урьдчилан үнэлэх шалгуур үзүүлэлт юм.

2.3. Ойлгомжтой байдал

Хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

2.4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал

Шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд тодорхой этгээдүүдэд үүрэг хүлээлгэсэн, аж ахуйн нэгж, байгууллагын салбарт хүндрэл үүсгэх зохицуулалтыг тусгаагүй, хуулийн үйлчлэлд хамаарах оролцогч талуудтай хэлэлцүүлэг хийж, саналыг авсан тул хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авах шаардлагагүй гэж үзэв.

2.5. Зардал

Хуулийн төсөл нь төрийн байгууллага, хуулийн этгээдэд холбогдох зардал үүсгэхээр зохицуулсан байх тул уг хоёр субъектэд үүсэх зардлыг “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцохоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгов.

2.6. Харилцан уялдаа

Хуулийн төслийг бүхэлд нь Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Нийгмийн халамжийн тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Төрийн албаны тухай, Компанийн тухай, Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай зэрэг холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.

ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Энэ хэсэгт хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгон авлаа. Энэхүү зүйл заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс хуульд нэмэлтээр орж буй голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож, тухайн сонгож буй зүйл заалтын үр нөлөөг судлах болно.

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт тус бүрээр авч үзвэл:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийнэ.

Монгол Улс нийгмийн халамжийн багц хуулийг 2012 онд шинэчлэн найруулж, АНТХ-ийн шинэчилсэн найруулга 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр батлагдаж, тухайн өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн байдаг. Уг хуулийг батлагдан хэрэгжиж эхэлснээс хойш Нийгмийн даатгалын ерөнхий хууль батлагдаж 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх болсон, мөн хуульд заасан бусад харилцааг зохицуулах зорилгоор Нийгмийн халамжийн тухай, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Эрүүл мэндийн тухай хуулиудтай уялдуулан 2021 оны 12 дугаар сарын 16-нд ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төлөвлөгөөг хэрэгжүүлэгч байгууллага, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үүрэг, 2022 оны 04 дүгээр сарын 22-нд ахмад настанд үзүүлэх дэмжлэг, ахмад настны ашиг сонирхлыг төлөөлөн хэрэгжүүлэх төрийн бус байгууллагад үзүүлэх дэмжлэг зэрэг харилцаанд өөрчлөлт орсон байна.

АНТХ нь зөвхөн нийгмийн халамжийн бодлого, үйл ажиллагааг зохицуулж байсан урьдах хуулийн үзэл баримтлалыг өөрчилж, ахмад настны эдлэх эрхийг хуульчлан баталгаажуулж, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрөл хүртээмжийг сайжруулах, ахмад настны нийгмийн хамгааллын талаар урд өмнө авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрсэн түвшнийг сайжруулсан, хамрах хүрээг өргөжүүлсэн олон чухал заалтуудыг нэмж тусгаснаараа олон улсын байгууллагаас тогтоосон хэм хэмжээнд нийцсэн бодлогын чухал баримт бичиг болсон. Мөн ахмад настантай холбоотой үйл ажиллагааг зохицуулсан Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай, Нийгмийн халамжийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулиуд үйлчилж байна.

Энэхүү хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдэд ахмад настныг нийгмийн идэвхтэй гишүүн байх, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрүүл насжилтыг дээдлэх, нийгмийн оролцоог нь нэмэгдүүлэх зэрэг зорилтуудыг тусгаж, тэдгээрийг хэрэгжүүлж ирсэн ч ахмад настны өмнө тулгарч буй олон асуудлууд шийдлээ хүлээсээр байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалд туссан үндэслэл, хэрэгцээ шаардлагаас дүгнэвэл хуулийн төсөл хэрэгжиж эхэлснээс хойш уг хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэхэд зарим саад бэрхшээл тулгарч байгаа тул уг шалтгааныг эрт илрүүлэх, давхар, хийдэл, зөрчлийг арилгах, цаашид хуулийг боловсронгуй болгоход хуулийн төслийн зорилго чиглэгдэж байна.

Аливаа хуулийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн байх ёстой учраас нэн түрүүнд хуулийн төслийн зорилгыг хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлага, үндэслэл болон зорилготой харьцуулан байдлаар үнэлсэн.

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн нэр томъёоны тодорхойлолт тусгасан хуулийн төслийн нэмэлт өөрчлөлт оруулсан хэсэг бүрийг сонгож авлаа.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэгт болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа.

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг хүснэгтийн дагуу тогтоолоо. Үүнд:

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 4, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 15, 16 дугаар зүйл	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх
2.	Практикт хэрэгжих байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь	Холбогдох зохицуулалтын практик нөхцөл байдалд шинжилгээ хийх
3.	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйл, хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах
4.	Зардал	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу тусад нь тооцно.	Тооцоолон гаргах
5.	Харилцан уялдаа	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгуудаар шалгах

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Энэ хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагыг хуулийн төсөлд томъёолсон зорилго, зорилт болон зохицуулалттай харьцуулан үзлээ.

Хуулийн төслийн үзэл баримтлалаас хүн ам зүйн өөрчлөлтийн улмаас нийт хүн амын дунд ахмад настнуудын эзлэх хувь хурдацтай өсөж байгаатай уялдуулан насжилтад бэлтгэх, ахмад настанд үзүүлэх урт хугацааны цогц тусламж үйлчилгээний болон ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг сайжруулах зорилгыг хангахад хуулийн төслийн зорилго оршиж байна.

Хуулийн төслийн зохицуулалтууд нь хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэсэн эсэх, тэдгээр нь зорилгыг хангах боломжтой байдлаар томъёологдсон эсэхийг үнэлэхээр хуулийн төслийн зорилгыг сонгож дүн шинжилгээ хийлээ.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.6. "ахмад настны эсрэг хүчирхийлэл" гэж аливаа этгээд ахмад настны эрх, эрх чөлөөг зөрчиж, түүний амь нас, эрүүл мэнд, бие махбод, сэтгэл санаанд болон ахмад настны өмчлөлийн байр, орон сууц, газар, бусад эд хөрөнгө, тэтгэвэр, мөнгөн хөрөнгийг нь түүний зөвшөөрөлгүйгээр болон айлган сүрдүүлэх, дарамт, шахалт үзүүлэн хүч хэрэглэн авч ашиглах зэргээр гэм хор учруулсан, эсхүл учруулахаар заналхийлсэн үйлдэл, эс үйлдэхүйг.

4.1.7. "ахмад настны цогц үнэлгээ" гэж эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтан ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлж, хэрэгцээний болон эрсдэлийн зэргийг үнэлэх мэргэжлийн үйл ажиллагааг;

4.1.8. "ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээ" гэж энэ хуулийн 4.1.7-д заасан үнэлгээнд суурилан, тухайн ахмад настны тулгамдсан асуудлыг эрэмбэлэн, цогц үйлчилгээнд төлөвлөгөөний дагуу хамруулах, үр дүнг эргэн хянах үйл ажиллагааг;

4.1.9. "ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээ" гэж ахмад настны асруулах эрэлт хэрэгцээ, нөхцөл байдалд үндэслэн өдрөөр, түр, урт хугацаанд байрлуулан асрах, байнга асрах төрөлжсөн асрамжийн, асралт гэр бүлээр асруулах, гэрээр асрах зэрэг бусад шаардлагатай үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагаар дамжуулан эсхүл хамтран төлбөртэй, төлбөрийн хөнгөлөлттэй, төлбөргүй нөхцөлөөр үзүүлэх үйл ажиллагааг;

4.1.10. "ахмад настанд үзүүлэх сэргээн засах үйлчилгээ" гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3.1.21 дэх заалтад заасан сэргээн засах цогц үйл ажиллагааг ахмад настанд үзүүлэхийг;

4.1.11. "ахмад настны эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ" гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3.1.19 дэх заалтад заасан цогц үйл ажиллагааг ахмад настанд үзүүлэхийг;

4.1.12. "ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээний мэргэжлийн удирдлага" гэж ахмад настанд үйлчилгээ үзүүлж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтныг онол, арга зүй, мэргэшлийн хувьд удирдан чиглүүлэх, дэмжих, зөвлөн туслах, хөгжүүлэх үйл ажиллагааг.

2017 онд шинэчилсэн найруулгаар батлагдсан Ахмад настны тухай хуульд ахмад настанд зөвлөгөө өгөх, өдрийн үйлчилгээ, явуулын үйлчилгээ болон өдрөөр эмчлэх, асран сувилах үйлчилгээ зэрэг шинэ төрлийн үйлчилгээг бий болгож, иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхээр тусгасан ч энэ шинэ үйлчилгээний хэрэгжилт тун хангалтгүй байна. Энэ төрлийн үйлчилгээнд тухайлбал 2022 оны байдлаар 2300 хүнд 600.0 сая төгрөг зарцуулж, нийт ахмад настны нэг хүрэхгүй хувийг хамруулж байгаа нь Монгол Улсад ахмад настныг дэмжих, хөгжүүлэх, нийгмийн амьдралд оролцуулах зэрэг үйлчилгээ байхгүйтэй адил байна гэсэн үг юм.

Ахмад настны эсрэг хүчирхийлэлд эдийн засгийн хүчирхийлэл нь нуугдмал бөгөөд өндөр хувь эзэлж байгааг ХЭҮК-оос хийсэн судалгаанаас гарсан. Мөн Солонгосын Ахмад настны хүчирхийллийн хуулийг судлан энэ заалтыг нэмсэн байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас “Номхон Далайн Баруун Бүсийн Эрүүл насжилтын үйл ажиллагааны төлөвлөгөө”-д “Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн халамжийн хэрэгцээг цогц байдлаар, урт хугацааны туршид тасралтгүй тусламж үйлчилгээгээр хангах” заалтыг хэрэгжүүлэхэд “Ахмад настны цогц тусламж, үйлчилгээ”-г өөрийн орны нөхцөл байдалтай уялдуулан эрх зүйн зохицуулалт хийхийг зөвлөсөн байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 3.1.13-т “Ахмад настанд урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэх хөгжлийн төвүүдийг байгуулна.”, 3.1.18-т “Ахмад настанд ... үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлнэ.” гэж тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 35 дугаар тогтоолын 3 дугаар зүйлд “Ахмад настны эрхийн хэрэгжилтийн талаар: а/ахмад настны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлэх зорилтыг эрчимжүүлэх, насжилтын үеийн өвчний эрсдэлийг нэмэгдүүлдэг хүчин зүйлүүдийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх; в/ахмадын асрамж, хамгаалал, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин нөхцөлийг бий болгох асуудлаар цогц бодлого боловсруулж, хэрэгжүүлэх.” асуудлыг тусгасан байдаг.

7 дугаар зүйл. Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ

7.1.7.ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээ;

7.1.10.ахмад настны хөгжлийг дэмжих үйлчилгээ;

7.1.11.ахмад настны дасгал хөдөлгөөн, эрүүл мэнд, нийгмийн оролцоог дэмжих үйлчилгээ;

7.1.12.ахмад настанд үзүүлэх сэргээн засах үйлчилгээ;

Асрамжийн үйлчилгээг ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээ буюу ахмад настны асруулах эрэлт хэрэгцээ, нөхцөл байдалд үндэслэн өдрөөр асрах, богино болон түр хугацаанд байрлуулан асрах, урт хугацаанд байрлуулан асрах, байнга асрах төрөлжсөн асрамжийн, асралт гэр бүлд байрлуулан асрах, гэрээр асрах зэрэг үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагаар дамжуулан төлбөртэй, бага төлбөртэй, төлбөргүй зэрэг олон хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагаа болгон өөрчилжээ.

Ахмад настны хөгжлийг дэмжих үйлчилгээ буюу ахмад настныг цаг үетэйгээ тохируулан сургах, хөгжүүлэх үйлчилгээг, сувиллын үйлчилгээ байгаа боловч тогтмол эрүүл мэндийг дэмжих сэргээн засалтын үйлчилгээ нэн шаардлагатай байгаа тул энэ чиглэлийн үйлчилгээг, эрүүл мэндийг дэмжих сургалт, үйлчилгээний хувьд өөрт нь болон байнгын асаргаатай ахмад настныг асарч байгаа иргэдэд зориулсан сургалт үйлчилгээ чухал байгааг хуулийн төсөлд тусгажээ.

7 дугаар зүйл. Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ

7.2.11.аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан болон өрх, сум, тосгоны эмч нь байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа иргэний эрүүл мэнд, ачааллыг үнэлэн, шаардлагатай бол тэднийг түр амраах, асруулагч ахмад настныг түр асрах төв, өдрийн асаргааны төв, сувилахуйн төвд түр байрлуулах, эрүүл мэндийн үйлчилгээ, хөнгөвчлөх эмчилгээнд

хамруулах, эсхүл гэр бүлийн бусад гишүүдийн асрамжид шилжүүлэх талаар гэр бүл гишүүдтэй нь зөвшилцөн шийдвэрлэх;

7.2.12.энэ хуулийн 4.1.7, 4.1.8, 4.1.12, 7.1-д заасан заасан үнэлгээ, үйлчилгээ, мэргэжлийн удирдлагын заавар болон энэ хуулийн үйлчилгээ үзүүлэх журмыг эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран баталж, хэрэгжүүлэх.

7.2.13.энэ хуулийн 7.1.6, 7.1.12, 7.1.13-т заасан үйлчилгээг эрх бүхий байгууллагаас магадлан итгэмжлэл авсан эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан байгууллагаар гүйцэтгүүлэх.

7.2.14.энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээг ахмад настан, ахмадын байгууллага, ахмад настны бүлэг, хоршоогоор гэрээлэн гүйцэтгүүлэхийг дэмжих;

7.2.15. энэ хуулийн 4.1.7-д заасан үнэлгээнд ахмад настан сайн дурын үндсэн дээр орох бөгөөд үнэлгээг хийхдээ ахмад настанд чирэгдэлгүй байхыг анхааран, зарим тохиолдолд цахимаар хийж болно

Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу хүнд хэлбэрийн хэвтрийн өвчтэй ахмад настануудыг гэр бүлдээ асарч байгаа иргэнд сар бүр тэтгэмж өгч байгаа нь хэвтрийн өвчтэй ахмад настантай өрхийг эдийн засгийн хүндрэлээс сэргийлэхэд дэмжлэг үзүүлж нөгөө талаар асаргаа үйлчилгээг гэрийн нөхцөлд хийж байгаа сайн талтай. Гэхдээ нөгөө талаар асарч байгаа иргэд нь ахмад настан голдуу байгаа нь нэг ахмад настан нөгөө ахмад настнаа асарч ядрах, сульдах, гэр бүлийн гишүүдэд асаргаа үйлчилгээний талаар сургалт байхгүйгээс мэдлэг дутмаг байх зэрэг хүндрэлтэй тулгардаг. Мөн хэвтрийн өвчтэй иргэний гэр бүлийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, асаргааны төлөвлөгөө гаргах, хэрэгцээт асаргааны хэрэгсэл бусад дэмжлэг үзүүлэх нь дутагдалтай байна.

2017 онд шинэчилсэн найруулгаар батлагдсан Ахмад настны тухай хуульд ахмад настанд зөвлөгөө өгөх, өдрийн үйлчилгээ, явуулын үйлчилгээ болон өдрөөр эмчлэх, асран сувилах үйлчилгээ зэрэг шинэ төрлийн үйлчилгээг бий болгож, иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхээр тусгасан ч энэ шинэ үйлчилгээний хэрэгжилт хангалтгүй тул энэ төрлийн үйлчилгээнд тухайлбал 2022 оны байдлаар 2300 хүнд 0.6 тэрбум төгрөг зарцуулж, нийт ахмад настны нэг хүрэхгүй хувийг хамруулж байгаа нь Монгол Улсад ахмад настныг дэмжих, хөгжүүлэх, нийгмийн амьдралд оролцуулах зэрэг үйлчилгээ дутмаг байжээ.

Ахмад настны тухай хуулийн ихэнх заалтын хэрэгжилтийг хангах чиг үүргийг орон нутгийн байгууллагад өгсөн боловч нэгдсэн арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангах байгууллага болон арга механизм нь тодорхойгүй, орон нутгийн төсөвт хангалттай хөрөнгө тусгагдаагүй зэрэг шалтгаантай байна. Түүнчлэн Ахмад настны тухай хуулийн дагуу үзүүлэх үйлчилгээ, дэмжлэг туслалцаа нь ахмадуудын тодорхой зорилтот бүлэгт бус, нийт ахмадуудын эрэлт хэрэгцээнд үндэслэх шаардлагатай нь харагдаж байна.

7 дугаар зүйл. Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ

7.3.Энэ хуулийн 7.2.14-т зааснаас бусад энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь ~~Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.8-д заасан шалгуур, журмыг хангасан~~ хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар ~~с-сөнгөн шалгаруулж~~, гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ. бөгөөд үйлчилгээ нь өрж, иргэний хүсэлтийн дагуу төлбөртэй байж болно.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.8-д заасан шалгуур, журмыг хангасан иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагууд ХХҮГ-ын дэргэдэх магадлан итгэмжлэлийн зөвлөлөөр орж магадлан итгэмжлэгдсэн байгууллагуудтай аймаг дүүрэг

гэрээ хийнэ гэсэн нь үйлчилгээ сайн хөгжиж чадахгүй байгаа орон нутагт хүндрэлтэй байна. Иймд орон нутагтаа сонгон шалгаруулалт хийж үйлчилгээг хөгжүүлэхээр тусгажээ.

7 дугаар зүйл. Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ

~~7.6.Энэ хуулийн 7.1.2, 7.1.3, 7.1.4-т заасан үйлчилгээг үзүүлэх зорилгоор тухайн нутгийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага нь сум, тосгон, хөрөө, багт "Ахмадын өргөө" байгуулан ажиллуулж болно.~~

7.6. Энэ хуулийн 7.1-д заасан зарим төрлийн үйлчилгээг аймаг, дүүрэг, сум, тосгон, хороонд үйл ажиллагаа явуулж байгаа ахмадын өргөө, ахмадын төв, сэргээн засах төв, идэвхтэй насжилтыг дэмжих төв, дасгалын клуб, бусад олон нийтийн төвүүд үйлчилгээ үзүүлж байна.

7.8.Төрийн болон орон нутгийн өмчит барилга, байгууламжид байрлаж, энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээг үзүүлж байгаа ахмадын өргөө, ахмадын төв, сэргээн засах төв, идэвхтэй насжилтыг дэмжих төв, дасгалын клуб, олон нийтийн төвийн урсгал зардлыг орон нутгийн төсвөөс гэрээний үндсэн дээр хэсэгчлэн болон санхүүжүүлнэ.

Ахмад настны урт хугацааны цогц тусламж үйлчилгээг хөгжүүлэхэд зөвхөн "Ахмадын өргөө" байгуулан ажиллуулах нь учир дутагдалтай байгаа тул ахмадын өргөө, ахмадын төв, сэргээн засах төв, эрүүл насжилтыг дэмжих төв, дасгалын клуб, олон нийтийн төв зэрэг олон хэлбэрээр аймаг, дүүрэг, сум, тосгон, хороонд ажиллуулахаар болохоор заасан.

Аймаг дүүргийн Хөдөлмөр, халамжийн халамжийн үйлчилгээний газруудад 1-2 ахмадын сувилал төрийн өмчид байдаг. Сүүлийн жилүүдэд хувийн амралт сувиллууд олон болсон, нөгөө талаар нэг сувилуулагчийн зардал 7 хоногт 210000 мянган төгрөг байгаа нь ажиллагсдын цалин, сувилуулагчийн хоол бусад зардалд хүрэлцэхгүй байгаа тухай тайлбарлаж зарим аймаг нь үйл ажиллагаагаа зогсоож зарим аймаг Засаг даргын тамгын газартаа шилжүүлсэн байдалтай байна. Иймд энэ сувиллын газруудыг шинэчлэн зохион байгуулж эрүүл насжилтыг дэмжих үйлчилгээ үзүүлдэг төв болгон зохион байгуулах боломжтой. Мөн ахмадын өргөө болон соёлын ордон, олон нийтийн төвүүд зэрэг барилга байгууламжид төрөл бүрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлэх боломжийг нээсэн байна.

Тухайлбал, эрүүл насжилтыг дэмжих үйлчилгээ үзүүлэх төвд ахмад настанд зориулсан сургалт, өдрийн үйлчилгээ, зөвлөгөө өгөх гэх мэт төрөл бүрийн үйл ажиллагааг хувийн хэвшил төрийн бус байгууллагатай гэрээлэх, мөн туршлагатай багш нартай цагийн хөлсийг тооцож гэрээлэх зэргээр үйлчилгээ үзүүлж, улмаар ахмад настны хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг хөгжүүлэх бүрэн боломжтой. Зарим төсвийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ахмад мэргэжилтний зөвлөгөө өгөх арга хэмжээний хүрээнд санхүүжүүлж болохоор тусгасан.

Эдгээртэй уялдан ахмад настны цогц тусламж үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэхийн тулд санхүүжилтийг тодорхой зааж, эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын байгууллагын, орон нутгийн зэрэг хамтарсан санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэжээ.

8 дугаар зүйл. Ахмад настны амьжиргааг дэмжих

8.1.1.хөл, гар, шүдний протез, сонсох, харах эрхтний ортопедийн хэрэгсэл, тэргэнцэр, нэн шаардлагатай тусгай хэрэгсэл худалдан авсан зардлын үнийн хөнгөлөлтийг гурван жилд нэг удаа эрүүл мэндийн даатгалын сангаас олгох;

8.1.3.тэжээн тэтгэх хүүхэдгүй, эсхүл хууль ёсны тэжээн тэтгэгч нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон, эсхүл Нийгмийн халамжийн тухай хуулийн 22 дугаар

зүйлийн 22.1.1-т заасан өрхийн ахмад настан, хүндэт донор ахмад настанд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад зориулан жилд нэг удаа мөнгөн тусламж эсхүл түлш худалдан авах эрхийн бичиг олгох;

8.1.5.ахмад настан нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр орон нутгийн харьяалал харгалзахгүй үнэ төлбөргүй /нийслэлд зориулалтын хөнгөлөлтийн картаар/ зорчих бөгөөд нийтийн тээврийн байгууллага ахмад настныг нийтийн тээврийн хэрэгслээр чөлөөтэй, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх;

8.1.6.энэ хуулийн 8.1.5-т заасан үнэ төлбөргүй зорчих төлбөрийг нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлсэн аймаг, нийслэлийн төсвөөс санхүүжүүлэх.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд протез, ортопедийн хөнгөлөлтөөс гадна тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн хөнгөлөлт үзүүлдэг. Ахмад насан хэрэв хөгжлийн бэрхшээлтэй бол тусгай хэрэгсэлд хамрагдана гэсэн тайлбараар энэ заалтад тусгай хэрэгслийн хөнгөлөлт үзүүлээгүй явсан нь ахмад настанд нэлээд чирэгдэлтэй Засгийн газрын тогтоолоор зарим тусгай хэрэгслийг олгодог байж.

Тиймээс ахмад настны хэрэгцээнд суурилан нэн шаардлагатай тусгай хэрэгсэл гэж нэмжээ.

Монгол Улсын хувьд өвлийн улиралд түлээ нүүрсний дэмжлэг үзүүлэх нь орлого багатай өрхийн хувьд хамгийн хэрэгцээ шаардлагатай үйлчилгээ байдаг. Одоогоор нийгмийн халамжийн хүрээнд ядуу өрхөд энэ үйлчилгээг үзүүлэхгүй байгаа тул Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай буюу ядуу өрхийн ахмад настанд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад зориулан жилд нэг удаа мөнгөн тусламж эсхүл түлш худалдан авах эрхийн бичиг олгож эхлэх ажил зохион байгуулагдахаар байна.

Нийслэлд орон нутгаас түр оршин сууж байгаа ахмад настны нийтийн тээврийн зардлын хөнгөлөлттэй байх заалт байгаагүйн улмаас өр үүсэж байсныг зохицуулжээ.

9 дүгээр зүйл. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

9.1.4.хөдөлмөрийн, боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран ахмад настан боловсролын байгууллагад ажиллах, насан туршийн боловсрол олгох чиглэлээр ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

9.1.5. хөдөлмөрийн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран сэргээн засалтын, идэвхтэй насжилтыг дэмжих болон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр эрүүл мэндийн байгууллагад ахмад настныг ажиллахыг дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

9.1.6.хөдөлмөрийн, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн, байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран үйлдвэржилтийг эрчимжүүлэх, хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, байгаль орчныг нөхөн сэргээх болон бусад чиглэлээр УИХ-аас баталсан үндэсний хэмжээний бодлого, стратегийн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд ахмад настан хувиараа хөдөлмөр, өрхийн аж ахуй эрхлэхийг техник, технологи, хөрөнгө санхүүгээр дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

9.1.7.энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээг энэ хуулийн 7.2.14-т заасны дагуу ахмад настан, ахмадын байгууллага, ахмад настны бүлэг, хоршоо, ахмадын оролцоотой байгууллага гэрээлэн гүйцэтгэхийг дэмжиж, энэ чиглэлээр хувиараа ажилласан ахмад настны цалин хөлсийг ажилласан цагаар, өдрөөр, сараар тооцон гэрээний дагуу хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон хууль тогтоомжийн дагуу бусад холбогдох сангаас санхүүжүүлэх.

9.9.Ажил олгогч нь хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7.3.4-т заасан тэтгэвэр авагч өөрөө хүсвэл ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тэтгэврийн даатгалд төлөх шимтгэл 8.5 хувийг Нийгмийн даатгалын санд төлөхгүй.

9.10.Төрийн албаны тухай хуулийн 27.4-т заасан нөхцөл үүссэн бол төрийн жинхэнэ албанд ажиллаж байсан, Ахмад настны тухай хуулийн 3.1, 3.2 дахь хэсэгт заасан иргэнийг мэргэжил, үр чадварыг нь харгалзан томилон ажиллуулж болно.

9.11.Аж ахуйн нэгж, байгууллага нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан насанд хүрсэн ахмад настныг өөрөө хүсэлт гаргаагүй байхад нь тэтгэвэрт гарахыг шаардах, энэ үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн гэрээ цуцлахыг хориглоно.

9.12.Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа хоёр хувиас доошгүй орон тоонд энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнийг хөдөлмөрийн хүнд, хортой, халуун нөхцөлтэй болон газрын доорх ажлын байрнаас бусад ажлын байранд ажиллуулна.

Ахмад настны тогтвортой орлогын эх үүсвэрийг хангах зорилгоор ахмад настнуудыг үргэлжлүүлэн хөдөлмөр эрхлүүлэхийг дэмжих, эдийн засгийн идэвхийг нь хадгалах, ахмад настнууд өөрийн чадавхыг амьдралынхаа туршид бүрэн дүүрэн ашиглах, тэдний мэргэжил, туршлага, үр чадварт түшиглэж залуу үеийг сургах, нөгөө талаар ахмад настан бүх нийтийн үйл хэрэгт идэвхтэй оролцох оролцоог дэмжин ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шаардлага байна.

Мөн ахмад настны хөдөлмөрлөх эрх зүйн орчныг нарийвчлан тодорхойлоогүйн улмаас насаар ялгаварлан гадуурхагдах, өөрөө хүсээгүй ч эрт тэтгэвэрт гаргах, ахмад настны цалин хөлсийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцох зэрэг үйлдлүүд гарсаар байна.

Тиймээс ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ахмад настан өөрөө нийгмийн даатгалын шимтгэл төлөх шаардлагагүй гэж үзвэл тухайн ахмад настныг авч ажиллуулж байгаа байгууллага тэтгэврийн даатгалын шимтгэл 8.5 хувийг төлөхгүй байх, 50 ба түүнээс дээш ажиллагсадтай аж ахуйн нэгжийн 4-өөс доошгүй хувьд ахмад настан авч ажиллуулах, мод, хүнсний ногоо тарих зэрэг байгаль орчны болон хүнс үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарт ахмад настныг ажиллахыг дэмжиж хөнгөлөлттэй зээл олгох, цалин хөлсийг зах зээлийн ханшаар ажилласан хугацаанд тооцон цагаар, өдрөөр гэх мэт уян хатан хэлбэрээр олгох, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр арга хэмжээг өргөжүүлэх зэрэг зохицуулалтыг оруулсан байна.

10 дугаар зүйл. Ахмад настны эрүүл мэндийг хамгаалах

10.1.2.эмчилгээ, сувилгаа зайлшгүй шаардлагатай ахмад настанд эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр магадлан итгэмжлэгдсэн дотоодын **рашаан** сувилалд амарч сувилуулах тохиолдолд тээврийн хэрэгслийн нэг талын зардал, эрхийн бичгийн **жишиг** үнийн 50 хувийг, хүндэт донор ахмад настанд 100 хувийг жилд нэг удаа нөхөн олгох;

Улсын хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн байгалийн рашаантай сувилал 20 байгаа бөгөөд хэрэв рашаан гэсэн үгийг хасвал магадлан итгэмжлэгдсэн дотоодын сувиллын тоо 50 орчим болохоор байна.

12 дугаар зүйл. Ахмад настанд үзүүлэх хүндэтгэл, насны хишиг

12.2. 65 болон түүнээс дээш настай ахмад настанд Цагаан сар: билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгнийг тохиолдуулан жил бүрийн 01 дүгээр сард, Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярыг тохиолдуулан жил бүрийн 6 дугаар сард улсын төсвөөс санхүүжүүлэн ахмад настны наснаас хамааран насны хишиг олгох бөгөөд насны **жишиг** *хишгийн хэмжээ*, олгох журмыг Засгийн газар батална.

12.3¹.Ахмад настны талаарх иргэд, байгууллага, олон нийтийн ойлголт хандлагыг сайжруулах, ахмад настны хуримтлуулсан мэдлэг, туршлагыг залуу үедээ өвлүүлэх, тэднийг

сонсох, ахмад настныг нийгэм, олон нийтийн дунд сайн сайхан ажиллаж, амьдрах нөхцөлийг дэмжих зорилгоор ахмадын өдрийг жил бүрийн 10 дугаар сарын 01, ахмадын долоо хоногийг 10 дугаар сарын 01-нээс 10 дугаар сарын 07-ны өдрүүдэд тэмдэглэнэ. Бүх шатны Засаг дарга нар, аж ахуйн нэгж, төрийн ба төрийн бус байгууллагууд энэ өдрүүдэд дээрх зорилгод нийцсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

12.3. Энэ хуулийн 12.2-т заасан насны хишиг дараахь хэмжээтэй байна:

12.3.1. 65-69 настай ахмад настанд тавин мянган төгрөг;

12.3.2. 70-79 настай ахмад настанд наян мянган төгрөг;

12.3.3. 80-89 настай ахмад настанд нэг зуун тавин мянган төгрөг;

12.3.4. 90, түүнээс дээш настай ахмад настанд хоёр зуун тавин мянган төгрөг.

Насны хишгийн хэмжээг хуульд мөнгөн дүнгээр заасан нь инфляцын өөрчлөлтөөр нэмэгдэхгүй, үнэ цэнийг бууруулах сөрөг талтай тул бусад тэтгэмж, тусламжийн хэмжээг тухай бүр Засгийн газар тогтоохоор тусгажээ.

Японы Ахмад настны тухай хуулийг харахад 9 сарын 15-нд ахмад настны өдөр, 9 сарын 15-21-ны хооронд ахмадын долоо хоногийг тэмдэглэж ахмад настныг дэмжих ахмад настны талаарх иргэд, байгууллага, олон нийтийн ойлголт хандлагыг сайжруулах, ахмад настны хуримтлуулсан мэдлэг, туршлагыг залуу үедээ өвлүүлэх, тэднийг сонсох, ахмад настныг нийгэм, олон нийтийн дунд сайн сайхан ажиллаж, амьдрах нөхцөлийг дэмжих мөн бүх шатны Засаг дарга нар, аж ахуйн нэгж, төрийн ба төрийн бус байгууллагууд энэ өдрүүдэд дээрх зорилгод нийцсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлдэг сайн туршлага байна.

Энэхүү туршлага нь манай улсад ч тохирч болох бөгөөд ахмадаа хүндэтгэх, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулж хэвших боломжтой юм.

13 дугаар зүйл. Ахмад настанд үзүүлэх дэмжлэгийн хэмжээ, үйлчилгээ үзүүлэх журам, санхүүжүүлэх эх үүсвэр

13.5. Энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээ, 8.1.1, 8.2.2, 10.1.2-т заасан дэмжлэгийн санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын сан, нийгмийн халамжийн сан, орон нутгийн төсвөөс болон ахмад настны оролцоотойгоор санхүүжүүлнэ.

13.6. Энэ хуулийн 13.5-д заасан үйлчилгээний жишиг үнэ, төлбөр, хөнгөлөлтийн хэмжээ, эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, нийгмийн халамжийн болон орон нутгийн төсвөөс хариуцах санхүүжилт болон иргэний хариуцах төлбөрийг нийгмийн хамгааллын, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран баталж, хэрэгжүүлнэ.

13.7. Энэ хуулийн 7.1 дэх хэсэгт заасан үйлчилгээнд зарцуулах хөрөнгө нь нийгмийн халамжийн сангаас ахмад настанд зориулан зарцуулах нийт хөрөнгөний 10 хувиас багагүй байна.

13.8. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ахмад настанд зарцуулах хөрөнгө нь эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн зардлыг оруулахгүйгээр тус сангийн тухайн жилийн нийт хөрөнгийн 10 хувиас багагүй байна.

13.9. Энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4-9.1.6, 9.9-д заасан арга хэмжээг санхүүжүүлэх зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон боловсролын, эрүүл мэндийн, хөдөлмөрийн, байгаль орчны, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад тусган санхүүжүүлнэ.

13.10. Энэ хуулийн 8.1.2, 10.1.2-т заасан амралт, сувиллын үйлчилгээний хөнгөлөлт, зардлыг ижил хугацаанд нэг байгууллагад нийгмийн халамжийн болон эрүүл мэндийн даатгалын сангаас давхардуулан олгохгүй.

13.11. Энэ хуулийн 7.1, 8.1.1, 8.1.2, 10.1.2 болон 10.2-т заасан үйлчилгээг үзүүлэхдээ үйлчилгээг цахимжуулах, үйлчилгээний давхардлыг арилгах, гэрээт байгууллагын санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн бодитоор олгох зорилгоор ахмад настны биометрик мэдээллийг ашиглаж болно.

Ахмад настны цогц тусламж үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэхийн тулд санхүүжилтийг тодорхой зааж, эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын байгууллагын, орон нутгийн зэрэг хамтарсан санхүүжилтийн эх үүсвэртэй болгон, үйлчилгээг хөгжүүлжээ.

Протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн тохируулга хийх талаар эмч, мэргэжилтэн зөвлөгөө өгч, эм, эмнэлгийн хэрэгслээр үйлчлүүлэх хөнгөлөлтөд хамруулах ажлыг эмийн хөнгөлөлт олгодогтой адилаар ахмад настан зах зээлээс хүссэн газраар үйлчлүүлэх боломжтой байлгах, өндөр өртөгтэй протезын санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын сан хариуцдаг болгох, нийгмийн халамжийн болон эрүүл мэндийн санхүүжилтийг нэгтгэн иргэнд яг хэрэгцээт үйлчилгээг үзүүлэх, санхүүжилтийг олон эх үүсвэртэй байгааг тодорхой болгох, нэгдсэн зохицуулалтаар хэрэгжүүлэх заалтыг тусгасан байна.

Мөн ахмадын рашаан сувилалд нийгмийн даатгалаас болон халамжийн сангаас хөнгөлөлт үзүүлдэг ба тус тусдаа хөнгөлөлтүүд нь давхцах хандлагатай тул санхүүжилтийг тодорхой болгосон байна.

14 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг

14.7. Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо, төсөвт байгууллага тухайн жилийн төсвийн зардалдаа тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална.

14.9. Аж ахуйн нэгж, байгууллага нь ахмадын сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал, мөнгөн хөрөнгийн зарцуулалтын талаар жил бүрийн 2 дугаар сарын 01-ний дотор харьяалагдах дээд байгууллагадаа тайлагнаж, хамт олондоо мэдээлнэ.

14.10. Ахмад настны нийгмийн болон хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлал, үл хайхрах, хүчирхийлэл, дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, таслан зогсоох, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хууль зүйн, хөдөлмөрийн, халамжийн, боловсролын, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналтын нэгжүүд холбогдох асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

14.11. Их, дээд сургуульд нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч, сувилагчийн мэргэжлээр суралцаж буй оюутны ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээний байгууллагад хийсэн сайн дурын ажлыг сургалтын хөтөлбөрийн дагуу хийх дадлагын ажлын цагт тооцож болно. Дадлагын цагт тооцох журмыг ахмад настны болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална."

Ахмадын санг байгуулахад төсвийн байгууллага нь үйл ажиллагааны орлого байдаггүй тул энэ санг байгуулахад хүнд байдаг. Иймд өөрийн төсөвт тусган хэрэгжүүлэх, мөнгөн хөрөнгийн зарцуулалтын ил тод байдлын талаар зохицуулсан байна.

Мөн ахмад настны ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, дарамтаас ангид байлгах чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагуудыг тодорхой болгож, оюутан залуусын нийгэмд тустай оролцоог нэмэгдүүлжээ.

15 дугаар зүйл. Ахмадын байгууллага

15.1. Ахмадын байгууллагын бүтэц нь ахмад настны олонхын нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалж нийгэмд үйлчилдэг, үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг өөрөө удирдах ёсны зарчимтай, бүх төрлийн татвараас чөлөөлөгдсөн, төрийн бус байгууллага (Монголын ахмадын холбоо), аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, аж ахуйн нэгж байгууллагын ахмадын хороо зөвлөл (цаашид "Ахмадын байгууллага" гэх)-өөс бүрдэнэ.

15.2.Энэ хуулийн 15.1-д заасан ахмадын байгууллагын үндсэн ажилтны цалин, тогтмол болон үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс, орон нутгийн ахмадын байгууллагын зардлыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвөөс, аж ахуйн нэгж, байгууллагын ахмадын хороо, зөвлөлийн зардлыг тухайн байгууллагын төсөв, орлогоос тус тус санхүүжүүлнэ.

15.3.Ахмад настны талаарх төрийн болон нутгийн захиргааны байгууллагын гүйцэтгэх зарим чиг үүргийг болон энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээг энэ хуулийн 15.1-д заасан байгууллагаар гүйцэтгүүлж, төсөл, арга хэмжээний зардлыг гэрээний үндсэн дээр хэсэгчлэн болон бүрэн санхүүжүүлж болно.

15.4.Энэ хуулийн 15.2-т заасан санхүүжилтийг авч энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээ, ахмад настны талаарх төрийн болон нутгийн захиргааны байгууллагын гүйцэтгэх зарим чиг үүргийг гүйцэтгэхдээ тухайн үйлчилгээний чиглэлээс хамааран нийгмийн халамжийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн, эрүүл мэндийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн, аймаг, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулан ажиллаж, үр дүн, санхүүжилтийн тайланг гэрээнд заасны дагуу тухай бүр тайлагнана.

15.5. Ахмадын байгууллага төрөөс ахмад настны талаар баримтлах бодлого, хууль тогтоомжид санал өгөх, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, оролцох, хяналт тавих, хөдөлмөр эрхлэлтэд дэмжлэг үзүүлэх, ахмадын мэдээллийн санг бүрдүүлэн, баяжуулж, дүгнэлт гаргана.

15.6.Ахмад настны асрамж сувилал, үйлчилгээний байгууллагуудыг магадлан итгэмжлэх зөвлөл, хүний эрхийн иргэний зөвлөл, амьжиргаа дэмжих зөвлөл, хохирогчдын нөхцөл, аюулгүй байдлын үнэлгээ, зэрэглэл тогтоох ажлын хэсэг, зөвлөлүүдэд төлөөллөө оролцуулна.

15.7. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилго бүхий төсөл, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ зэрэгт зориулагдах төсвийн санхүүжилтийг ахмадын байгууллагад шилжүүлэн гүйцэтгүүлж болно.

15.8. Энэ хуулийн 15.2, 15.4, 15.7-д заасан гэрээ, хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ, гэрээний хэрэгжилт, санхүүжилтийн тайлан нь олон нийтэд ил тод, нээлттэй байна.

15.9.50 ба түүнээс дээш ажиллагаатай ахмад настантай төрийн болон төрийн бус, аж ахуйн нэгж байгууллагын ахмадын зөвлөл тогтмол үйл ажиллагаатай, тухайн байгууллагыг ахмадуудтайгаа харилцах үндсэн чиг үүрэгт зөвлөх, туслах үүрэгтэй байх бөгөөд ахмад зөвлөлийн нэг ажилтныг орон тоондоо багтаан цалинжуулна.

Ахмадын байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор санхүүжилт, үйл ажиллагааны үр дүн, ил тод байдлыг хангуулж, ахмад настанд үзүүлэх үйлчилгээг ахмадын байгууллага гэрээгээр гүйцэтгэх боломжийг бүрдүүлсэн байна.

Мөн 50 ба түүнээс дээш ажиллагсадтай аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын ахмадын зөвлөл нь байнгын орон тоотой тогтмол үйл ажиллагаа явуулах боломжийг нээсэн байна.

16 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

16.3.Энэ хуулийн 14.7-д заасан ахмадын сангийн хуримтлал үүсгээгүй тохиолдолд төсөв захирагчид байгуулбал зохих ахмадын сангийн дүнгийн 0.3 хувиар торгууль ногдуулж Зөрчлийн тухай хуулиар хариуцлага тооцно.

Ахмадын сантай холбоотой хариуцлагын заалт оруулснаар аж ахуйн нэгж, байгууллагууд хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, тухайн харилцааг хэрхэн хэрэгжүүлэх ойлголтыг бататгасан байна.

3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Ахмад настны тухай хуулийн ихэнх заалтын хэрэгжилтийг хангах чиг үүргийг орон нутгийн байгууллагад өгсөн боловч нэгдсэн арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар

хангах байгууллага болон арга механизм нь тодорхойгүй, орон нутгийн төсөвт хангалттай хөрөнгө тусгадаггүй байсан. Ахмад настны тухай хуулийн дагуу үзүүлэх үйлчилгээ, дэмжлэг тусалцаа нь ахмадуудын тодорхой зорилтот бүлэгт бус, нийт ахмадуудын эрэлт хэрэгцээнд үндэслэсэн байна.

Одоогоор манайд ахмад настанд зөвхөн протез, ортопедийн хөнгөлөлт үзүүлэх, амралт рашаан сувиллын хөнгөлөлтийг жилд нэг удаа үзүүлэхээс өөр тэдэнд зориулсан байнгын тогтмол үзүүлдэг төрөл бүрийн сэргээн засалтын болон хөгжил, хамгааллын үйлчилгээ дутагдалтай байсныг цогц тусламж үйлчилгээний тогтолцоог бүрдүүлж, санхүүжилтийг тодорхой болгож, урт хугацааны тусламж үйлчилгээг хөгжүүлэх боломж бүрдсэн.

Хүн ам насжихын хирээр залуу ажилчдын эзлэх хувь буурах тул мэдлэг чадвартай, ажил амьдралын туршлагатай ахмад ажилчдын хөдөлмөр эрхлэлтийг зохистой хэлбэрээр дэмжихийн тулд ахмад настнуудыг үргэлжлүүлэн хөдөлмөр эрхлүүлэхийг дэмжих, эдийн засгийн идэвхийг нь хадгалах, ахмад настнууд өөрийн чадавхыг амьдралынхаа туршид бүрэн дүүрэн ашиглах, тэдний мэргэжил, туршлага, ур чадварт түшиглэж залуу үеийг сургах, нөгөө талаар ахмад настан бүх нийтийн үйл хэрэгт идэвхтэй оролцох олон талт бодлогыг батлан хэрэгжүүлэхээр хуулийн төсөлд оруулсан нь тодорхой эерэг үр дүн гарахаар байна.

Сүүлийн жилүүдэд гэр бүлийн хүчирхийллийн дуудлагад ахмад настны эсрэг хүчирхийлэл нэмэгдэж байна тул ахмад настанд тохиолдож байгаа эдийн засгийн хүчирхийлэл буюу тэтгэвэр, тэтгэмжийг нь зөвшөөрөлгүй зарцуулах, барьцаалж зээл авах, өмч хөрөнгийг нь дур мэдэн зарцуулах, ашиглах зэрэг асуудалд Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулж хариуцлагын тогтолцоог бүрдүүлсэн.

Мөн Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд ахмадын байгууллагын статус, санхүүжилтийг тодорхой зааж өгсөн байна.

3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Ойлгомжтой байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг гүйцэтгэлээ.

Эдгээрээс үзэхэд хуулийн төслийн бүтэц, хэлбэр, эх бичвэрийн агуулга, хэл зүй, эшлэл, найруулгад тавих нийтлэг шаардлага хангагдсан байна.

3.4. “Зардал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг “Аргачлал батлах тухай” Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлалын дагуу тооцлоо.

Энэ хууль батлагдсанаар ахмад настанд төрөөс үзүүлэх дэмжлэг үйлчилгээнд хамрагдах ахмад настны тоо өсөж 50.0 орчим тэрбум төгрөгийн нэмэлт хөрөнгө шаардагдана. Нийт зардлын 80 гаруй хувь ахмад настны хөгжлийн болон эрүүл

мэндийн урьдчилан сэргийлэх, сэргээн засах зэрэг ахмад настны эрүүл мэнд, нийгмийн оролцоог дэмжихэд чиглэсэн иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгэх болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд зарцуулагдахаар байна.

4.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоо шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзлээ. Хуулийн төслийн уялдаа холбоо /Аргачлалын 4.10-т заасан шалгуурыг хангасан эсэх/

Д/д	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ		
1.	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм	Судалгаагаар зөрчилтэй тогтоогдоогүй	энэ	төрлийн асуудал
2.	Хуулийн төслийн хууль тогтоомж гэсэн хэсэгт заасан хуулийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм	Судалгаагаар зөрчилтэй тогтоогдоогүй	энэ	төрлийн асуудал
3.	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёонд нийцэж байгаа эсэх	Тийм	Судалгаагаар зөрчилтэй тогтоогдоогүй	энэ	төрлийн асуудал
4.	Хуулийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Тийм	Судалгаагаар зөрчилтэй тогтоогдоогүй	энэ	төрлийн асуудал
5.	Хуулийн төслийн зүйл, заалт хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Үгүй	Судалгаагаар зөрчилтэй тогтоогдоогүй	энэ	төрлийн асуудал
6.	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм	Хуулийн төслөөр хэрэгжүүлэх тодорхой тусгасан		хуулийг этгээдийг
7.	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Үгүй	Судалгаагаар зөрчилтэй тогтоогдоогүй	энэ	төрлийн асуудал
8.	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Үгүй	Судалгаагаар зөрчилтэй тогтоогдоогүй	энэ	төрлийн асуудал
9.	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Тийм	Хуулийн төслөөр төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэхээр тодорхой тусгасан		
10.	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Тийм	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт тусгасан		
11.	Хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл	Үгүй	Судалгаагаар зөрчилтэй тогтоогдоогүй	энэ	төрлийн асуудал

	ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;		
12.	Монгол Улсын Үндсэн хууль, болон Монгол улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Үгүй	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй тогтоогдоогүй асуудал
13.	Хуулийн төслийн зүйл, заалт жөндөрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	-	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй тогтоогдоогүй асуудал
14.	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	-	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй тогтоогдоогүй асуудал
15.	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй тогтоогдоогүй асуудал
16.	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Тийм	Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.3-т энэ талаар зохицуулсан

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

4.1. Дүгнэлт

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ шалгуур үзүүлэлт бүрээр дараах байдлаар үнэлж дүгнэлээ.

Зорилгод хүрэх шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийхэд зорилгодоо хүрэх байдлын шалгуур үзүүлэлтэд нийцсэн гэж дүгнэж байна.

Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэх, хэрэгжүүлэх субъект, байгууллага нь тодорхой эсэх, тэдгээр байгууллагад тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг урьдчилан үнэлгээ хийхэд практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтэд нийцсэн гэж дүгнэж байна.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангаж, хоёрдмол утгатай үг хэллэг, хүч оруулсан үг хэллэг, ойлголтын зөрүү үүсэхээр томъёолсон байдал зэрэг асуудал тогтоогдоогүй тул ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтэд нийцсэн гэж дүгнэж байна.

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр:

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгахад харилцан уялдаатай байдлыг хангасан гэж дүгнэж байна.

4.2. Зөвлөмж

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг тооцох ажиллагааны үр дүнд гарсан дүгнэлтэд тулгуурлан үзэхэд шалгуур үзүүлэлтүүдийн хувьд бүгд нийцсэн хэмээн дүгнэгдсэн тул хуулийн төслийг зохих хууль тогтоомжид нийцүүлэн Улсын Их Хуралд өргөн барьж, хэлэлцүүлэн батлуулах шаардлагатай хэмээн зөвлөж байна.